



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdeneega@gmail.com

Ньюбаланс аудит ХХК-ийн Захирал: Б.Лхагвадорж

Утас: 99101901 Цахим хаяг:

Newbalance.lhagvaa@gmail.com

Аудитор: Ё.Байгалмаа

Утас: 99025579 Цахим хаяг: yobaigal5579@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/152
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.АМГАЛАН
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>196,762,651.76</u>	<u>170,191,592.28</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	196,762,651.76	170,191,592.28
351	Түүхий эд материал	1,415,400.00	1,575,800.00
35130	Эм боох материал	1,415,400.00	1,575,800.00
354	Хангамжийн материал	187,157,251.76	161,250,792.28
35410	Бичиг хэргийн материал	2,329,303.35	3,946,534.55
35420	Аж ахуйн материал	73,306,479.26	81,183,465.04
35440	Түлш, шатах тослох материал	7,284,834.00	1,541,250.00
35450	Барилгын засварын материал	31,475,841.50	18,758,675.50
35460	Хүнсний материал	15,392,621.00	553,300.00
35470	Бусад хангамжийн материал	57,368,172.65	55,267,567.19
35600	Мал амьтад	8,190,000.00	7,365,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,240,025,615.76</u>	<u>2,571,960,671.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,240,025,615.76	2,571,960,671.00
392	Биет хөрөнгө	2,131,790,815.76	2,462,088,871.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,774,149,050.00	2,720,087,950.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-745,302,794.72	-455,388,102.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00.00	23,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж компьютер)	180,678,520.65	123,217,779.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	-128,447,447.97	-21,267,437.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,560,208.51	88,934,105.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,402,501.09	-38,298,174.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,171,700.00	10,451,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,360,599.40	-6,332,152.62
39217	Ном	14,744,679.78	17,183,201.86
393	Биет бус хөрөнгө	108,234,800.00	109,871,800.00
39301	Програм хангамж	737,000.00	1,637,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-737,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	108,234,800.00	108,234,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,436,788,267.52</u>	<u>2,742,152,263.28</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,436,788,267.52</u>	<u>2,742,152,263.28</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,436,788,267.52	2,742,152,263.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	676,390,091.02	676,390,091.02
51101	Өмч: - төрийн	676,390,091.02	676,390,091.02
512	Хуримтлагдсан үр дүн	1,056,247,758.61	1,392,467,074.37
51210	Өмнөх үеийн үр дүн	1,056,247,758.61	1,435,955,221.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-43,488,146.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	704,150,417.89	673,295,097.89

6	ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,436,788,267.52	2,742,152,263.28
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,333,754,494.63	1,435,117,340.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,674,180.63	90,835,061.96
120	Нийтлэг татварын бус орлого	8,674,180.63	90,835,061.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,294,186.50	2,865,095.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,294,186.50	2,865,095.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	261,176,914.00	279,958,978.55
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,063,903,400.00	1,064,323,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,113,100.00	9,651,178.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,053,244.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,113,100.00	4,597,934.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	258,063,814.00	270,307,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	258,063,814.00	270,307,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,359,905,735.27	1,474,569,122.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,359,905,735.27	1,459,269,122.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,262,746,465.27	1,363,103,943.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	761,285,078.00	783,840,719.00
210101	Үндсэн цалин	629,791,934.00	547,594,040.00
210102	Нэмэгдэл	54,385,698.00	188,646,535.00
210104	Урамшуулал	77,107,446.00	47,600,144.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,251,241.00	102,136,298.00
210201	Тэтгэврийн даатгал	66,502,072.00	72,037,998.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,610,616.00	7,524,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,088,493.00	6,019,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,459,096.00	1,505,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,590,964.00	15,048,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,940,613.00	260,489,233.00
210301	Гэрэл, цахилгаан	8,065,493.00	9,201,990.00
210302	Түлш, халаалт	236,825,120.00	251,237,243.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,614,247.00	28,098,619.46
210401	Бичиг хэрэг	297,000.00	777,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,499,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	735,000.00
210404	Ном, хэвлэл	5,940,500.00	2,893,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,771,452.00	510,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,847,210.00	7,700,464.00
210408	Бараа материал акталсны зардал	7,108,085.00	7,983,455.46
2105	Нормативт зардал	37,153,718.50	41,949,700.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,090,435.00	931,600.00
210502	Хоол, хүнс	34,983,683.50	40,558,100.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	79,600.00	460,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,478,200.00	10,607,800.00
210604	Урсгал засвар	4,478,200.00	10,607,800.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	378,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	378,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	1,544,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	944,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,523,367.77	134,058,973.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	80,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,172,050.00	7,421,223.35
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,351,317.77	126,557,749.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,159,270.00	96,165,179.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,091,255.00	20,673,636.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,091,255.00	20,373,636.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	72,335,192.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	72,335,192.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,752,501.00	3,156,351.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,752,501.00	3,156,351.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,315,514.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,315,514.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	15,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	15,300,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,151,240.64	-39,451,782.10
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,170,947.38	4,036,364.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,170,947.38	4,036,364.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-21,170,947.38	-4,036,364.71
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-47,322,188.02	-43,488,146.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	676,390,091.02	704,150,417.89	1,108,036,546.63	2,488,577,055.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-4,466,600.00	-4,466,600.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	676,390,091.02	704,150,417.89	1,103,569,946.63	2,484,110,455.54
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-47,322,188.02	-47,322,188.02
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	676,390,091.02	704,150,417.89	1,056,247,758.61	2,436,788,267.52
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	676,390,091.02	704,150,417.89	1,056,247,758.61	2,436,788,267.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	379,707,462.57	379,707,462.57
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	676,390,091.02	704,150,417.89	1,435,955,221.18	2,816,495,730.09
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-30,855,320.00	00.00	-30,855,320.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-43,488,146.81	-43,488,146.81
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	676,390,091.02	673,295,097.89	1,392,467,074.37	2,742,152,263.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,327,877,714.00	1,344,282,278.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,327,877,714.00	1,344,282,278.55
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,063,903,400.00	1,064,323,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,910,500.00	9,651,178.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,053,244.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,910,500.00	4,597,934.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	258,063,814.00	270,307,800.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	258,063,814.00	270,307,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН(2)	1,290,767,714.00	1,312,596,478.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,290,767,714.00	1,312,596,478.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,194,197,789.00	1,230,806,137.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	761,069,119.00	783,840,719.00
210101	Үндсэн цалин	629,545,473.00	515,295,583.00
210102	Нэмэгдэл	54,416,200.00	220,944,992.00
210104	Урамшуулал	77,107,446.00	47,600,144.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,467,200.00	102,136,298.00
210201	Тэтгэврийн даатгал	67,366,200.00	72,037,998.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,275,000.00	7,524,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,820,300.00	6,019,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,454,700.00	1,505,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,551,000.00	15,048,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,162,613.00	257,385,649.00
210301	Гэрэл, цахилгаан	8,065,493.00	9,201,990.00
210302	Түлш, халаалт	235,047,120.00	245,493,659.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	2,690,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,951,112.00	22,712,914.55
210401	Бичиг хэрэг	133,000.00	1,540,904.55
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	735,000.00
210404	Ном, хэвлэл	6,083,000.00	3,005,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,771,452.00	509,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,213,660.00	9,422,310.00
2105	Нормативт зардал	54,613,695.00	39,978,623.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,672,085.00	912,100.00
210502	Хоол, хүнс	36,882,690.00	38,488,523.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,058,920.00	578,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,288,700.00	12,465,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,140,000.00	00.00
210602	Тавилга	00.00	2,700,000.00
210604	Урсгал засвар	4,148,700.00	9,765,800.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	378,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	378,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	3,469,434.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,869,434.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,145,350.00	8,438,700.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,145,350.00	8,438,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,569,925.00	81,790,341.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,501,910.00	6,298,798.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,501,910.00	5,998,798.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	72,335,192.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	72,335,192.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,752,501.00	3,156,351.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,752,501.00	3,156,351.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,315,514.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,315,514.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>37,110,000.00</u>	<u>31,685,800.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,110,000.00	31,685,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,110,000.00	31,685,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,110,000.00	31,685,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,110,000.00	31,685,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-37,110,000.00</u>	<u>-31,685,800.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/ төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,334,631,100.00	1,259,139,557.00	75,491,543.00	94.3%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,334,631,100.00	1,259,139,557.00	75,491,543.00	94.3%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,306,638,000.00	1,252,840,759.00	53,797,241.00	95.9%

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	804,276,500.00	783,840,719.00	20,435,781.00	97.5%
210101	Үндсэн цалин	552,526,400.00	515,295,583.00	37,230,817.00	93.3%
210102	Нэмэгдэл	203,950,100.00	220,944,992.00	16,994,892.00	108.3%
210104	Урамшуулал	47,800,000.00	47,600,144.00	199,856.00	99.6%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,577,500.00	102,136,298.00	6,441,202.00	94.1%
210201	Тэтгэврийн даатгал	76,406,200.00	72,037,998.00	4,368,202.00	94.3%
210202	Тэтгэмжийн даатгал	8,042,800.00	7,524,900.00	517,900.00	93.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,434,300.00	6,019,700.00	414,600.00	93.6%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,608,600.00	1,505,000.00	103,600.00	93.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	16,085,600.00	15,048,700.00	1,036,900.00	93.6%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	260,542,000.00	257,385,649.00	3,156,351.00	98.8%
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.00	9,201,990.00	798,010.00	92.0%
210302	Түлш, халаалт	249,342,000.00	245,493,659.00	3,848,341.00	98.5%
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	2,690,000.00	-1,490,000.00	224.2%
2104	Хангамж, бараа материалын зардал	19,177,200.00	19,066,570.00	110,630.00	99.4%
210401	Бичиг хэрэг	1,033,800.00	1,216,270.00	-182,470.00	117.7%
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,500,000.00	00.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	735,300.00	735,000.00	300.00	100.0%
210404	Ном, хэвлэл	404,400.00	112,000.00	292,400.00	27.7%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	509,600.00	509,600.00	00.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,994,100.00	8,993,700.00	400.00	100.0%
2105	Нормативт зардал	62,988,000.00	39,978,623.00	23,009,377.00	63.5%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	912,100.00	912,100.00	00.00	100.0%
210502	Хоол, хүнс	60,263,700.00	38,488,523.00	21,775,177.00	63.9%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,812,200.00	578,000.00	1,234,200.00	31.9%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,258,600.00	40,091,600.00	167,000.00	99.6%

210601	Багаж, техник, хэрэгсэл	19,692,800.00	19,525,800.00	167,000.00	99.2%
210602	Тавилга	10,800,000.00	10,800,000.00	00.00	100.0%
210604	Урсгал засвар	9,765,800.00	9,765,800.00	00.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	728,000.00	378,000.00	350,000.00	51.9%
210702	Дотоод албан томилолт	728,000.00	378,000.00	350,000.00	51.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,651,500.00	1,524,600.00	126,900.00	92.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,051,500.00	924,600.00	126,900.00	87.9%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	00.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8438700.00	8438700.00	00.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,438,700.00	8,438,700.00	00.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27993100.00	6298798.00	21,694,302.00	22.5%
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,993,100.00	6,298,798.00	21,694,302.00	22.5%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,693,100.00	5,998,798.00	21,694,302.00	21.7%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00	00.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,334,631,100.00	1,259,139,557.00	75,491,543.00	94.3%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,064,323,300.00	991,988,108.00	72,335,192.00	93.2%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,064,323,300.00	991,988,108.00	72,335,192.00	93.2%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	270,307,800.00	267,151,449.00	3,156,351.00	98.8%
132001	Орон нутгийн төсвөөс	270,307,800.00	267,151,449.00	3,156,351.00	98.8%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	69.00	69.00	00.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00	00.00	100.0%

620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00	00.00	100.0%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	611.00	512.00	99.00	83.8%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	611.00	512.00	99.00	83.8%
630001	Төрийн өмчит ЕБС	611.00	512.00	99.00	83.8%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,651,178.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,651,178.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		9,651,178.55
2104	Хангамж, бараа материалын зардал		3,646,344.55
210401	Бичиг хэрэг		324,634.55
210404	Ном, хэвлэл		2,893,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		428,610.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,004,834.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,004,834.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	9,651,178.55
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,651,178.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,053,244.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,597,934.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Ё.Байгалмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах Аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15/113 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургууль нь хамран сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжил оролцоог дээшлүүлэх, боловсон хүчний нөөц, чадавхийг чанаржуулах, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн хамт олон байх зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,359.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 27.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 305.4 сая төгрөгөөр буюу 11,1 хувиар өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0,0	0,0	0,0
Бараа материал	196.7	170.2	-26.6
Биет хөрөнгө	2,131.8	2,462.1	330.3
Биет бус хөрөнгө	108.2	109.9	1,6
Нийт хөрөнгө	<u>2,436.8</u>	<u>2,742.2</u>	305.4
Дансны өглөг	0,0	0,0	0,0
Засгийн газрын хувь оролцоо	676.4	676.4	
Хуримтлагдсан үр дүн	1,056.3	1,392.5	336.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>2,436.8</u>	<u>2,742.2</u>	305.4

Бараа материалын дансны үлдэгдэл 170.2 сая төгрөг болж, 26.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд түлш шатах тослох материал, барилгын материал, хүнсний материал, бусад хангамжийн материал зэрэг дансны үлдэгдэл буурахад нөлөөлжээ. Тайлант хугацаанд 8.0 сая төгрөгийн аж ахуйн материал актаар хассан байна.

Биет хөрөнгийн дансны үлдэгдэл 2,462.1 сая төгрөг болж, 330.3 сая төгрөгөөр өссөн нь тус сургуулийн төгсөгч автомашин хандивласан, БШУЯ-наас үнэ төлбөргүй орлогоор цахим сургалтын тоног төхөөрөмж хүлээн авсан, тайлант онд үндсэн хөрөнгийг дахин үнэлж орлого авсантай холбоотой байна.

Дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо данс 676.4 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 1,392.5 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 673.3 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,435.1 сая төгрөг, нийт зардал 1,474.6 сая төгрөг, тайлант үеийн үр дүн -43.5 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсантай холбоотой 30.9 сая төгрөг, хуримтлагдсан үр дүнд 379.7 сая төгрөгөөр нөлөөлж нийт цэвэр өмчийн дүн 2,742.2 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны төсвийн төслийг 1,339.2 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 1,284.9 сая төгрөгөөр анх баталж, 49.7 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийж, 1,334.6 сая төгрөгийн төсөв баталсан байна. Төсөв нэмэгдсэн шалтгаан нь ажилласан жилээс хамаарсан цалингийн шатлал, зэрэглэл өссөн, харин нормативт зардал буюу үдийн цайны зардал буурсан нь ковидын хөл хорионы улмаас танхимын сургалт буурсантай холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд 1,334.6 сая төгрөг батлагдсанаас 1,334.6 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, 1,259.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 75.5 сая төгрөг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвөөс 10 хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 4.6 сая төгрөг, Боловсролын газраас 5.1 сая төгрөгийг тус тус хүлээн авч, боловсролын чанарын шинэчлэл болон бусад үйл ажиллагаанд 9.7 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Дэлхий нийтийг хамарсан Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хөл хорионы үед сурагчдын хичээл, хүүхдийн дунд зохиогдох хичээлээс гадуурх сургалт хүмүүжлийн ажлын цар хүрээ хязгаарлагдмал байдалтай байсан тул цахим болон зайны сургалтууд тодорхой хугацаанд явагдсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 75.5 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: Цалин хөлс болон НДШ-с 26.9 сая төгрөг, тогтмол зардлаас 3.2 сая төгрөг, хоол хүнсний зардлаас 23.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 0.6 сая төгрөг, үдийн цайны зардлаас 21.7 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,339.2 сая төгрөгийн 151 мэдээллээс 1,295.2 сая төгрөгийн 134 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, шилэн дансны мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн мэт харагдавч доторхи 44.0 сая төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож дутуу мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим хуулийн нийцлийн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоог дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 105.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 61.1 сая төгрөгийн алдааг залруулж, 44.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийг 59.4 сая төгрөгөөр дутуу тооцоолсон, нэмэлт санхүүжилтийн тайланд 1.7 сая төгрөгийг дутуу тайлагнасан зэргийг залруулсан болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг мэдээлсэн боловч 14 мэдээлэл дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

1.2. Зөвлөмж. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургууль	3	105.1	2	61.1					1	44.0

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ 11/25

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ

БЭЛТГЭСЭН:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Б.ЛХАГВАДОРЖ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

Д.ГЭРЭЛЧУЛУУН

АУДИТОРЫН ТУСЛАХ

Ё.БАЙГАЛМАА